



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/144

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Мөнх жаргалант хүлэг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн дэмжлэг, тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Б.Сумхүү - Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн менежер

А.Чимэгмаа - Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн ажилтан

Г.Эрдэнэжаргал - “Мөнх жаргалант хүлэг” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн дэмжлэг, тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Баярсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН